



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОЁЛЫН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: Munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Залруулсан алдаа	21
4.2 Албан шаардлага	21
4.3 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БХТ	Барилгын хөгжлийн төв
ДБҮЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар
НА	Нотлох ажил
ЗГ	Засгийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.ОЮУНБИЛЭГ
ТАНАА

2022.02.25 № 07/404
тантай _____ -ныг № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10\Bichig_Kherag\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Газар - 57.Docx

001050436

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	197,246,816.90	219,467,778.30
33	АВЛАГА	-	6,909,755.30
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	6,909,755.30
34	УРЬДЧИЛГАА	82,496,000.00	43,770,000.0
34600	Урьдчилж гарсан зардал	82,496,000.00	43,770,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	114,750,816.90	168,788,022.90
35100	Түүхий эд материал	46,041,357.00	52,707,210.00
35110	Тусгай зориулалттай материал	42,168,760.00	50,776,210.00
35130	Эм боох материал	3,872,597.00	1,931,000.00
35400	Хангамжийн материал	68,709,459.90	116,080,812.90
35410	Бичиг хэргийн материал	10,684,310.00	23,713,500.00
35420	Аж ахуйн материал	4,190,434.20	14,838,431.20
35430	Сэлбэг хэрэгсэл	-	852,850.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	53,834,715.70	75,176,031.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,307,840,580.30	1,567,259,609.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,307,840,580.30	1,567,259,609.50
39200	Биет хөрөнгө	700,300,580.20	717,818,329.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,166,666.60)	(3,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	445,274,923.10	556,234,988.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,455,372.50)	(105,235,401.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	300,677,758.00	316,892,634.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,732,061.60)	(54,946,891.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,645,000.00	6,645,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(443,000.00)	(1,772,000.00)
39300	Биет бус хөрөнгө	607,540,000.00	849,441,280.10
39301	Программ хангамж	7,800,000.00	7,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(259,999.90)	(1,039,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	600,000,000.00	842,681,280.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,505,087,397.30	1,786,727,387.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,505,087,397.30	1,786,727,387.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,505,087,397.30	1,786,727,387.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,505,087,397.30	1,786,727,387.90
51210	Өмнөх үеийн үр дүн	-	1,505,087,397.30
51220	Тайлант үеийн үр дүн	1,505,087,397.30	281,639,990.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,505,087,397.30	1,786,727,387.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,907,668,231.00	5,818,275,575.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	768,658,031.00	418,685,345.30
120	Нийтлэг татварын бус орлого	768,658,031.00	418,685,345.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	335,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	335,000.00	400,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	768,323,031.00	416,370,345.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,915,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,139,010,200.00	5,399,590,230.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,128,990,200.00	3,898,126,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,128,990,200.00	3,898,126,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,020,000.00	1,501,463,930.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	56,486,175.30
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,444,977,755.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,402,580,833.70	5,502,580,068.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,402,580,833.70	5,502,580,068.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,109,769,441.80	4,360,316,250.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	500,164,242.10	1,690,231,512.90
210101	Үндсэн цалин	278,886,607.10	1,187,892,967.30
210102	Нэмэгдэл	94,455,192.00	260,020,807.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,964,000.00	160,824,973.60
210104	Урамшуулал	82,858,443.00	81,492,765.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,329,259.00	219,613,156.70
210201	Тэтгэврийн даатгал	42,513,789.00	152,272,258.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,001,619.00	16,944,065.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,001,297.00	13,619,731.60
210204	Ажилгүйдлийн даатгал	982,960.00	3,295,242.70
210205	Эрүүл мэндийн даатгал	9,829,594.00	33,481,857.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	144,000,000.00
210304	Байрны түрээс	-	144,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,937,288.50	116,795,543.20
210401	Бичиг хэрэг	6,517,190.00	30,223,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,439,253.00	45,693,386.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,529,989.70	35,606,922.20
210404	Ном, хэвлэл	4,338,300.00	445,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,112,555.80	3,976,285.00
2105	Норматив зардал	1,428,930.00	3,541,597.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,428,930.00	3,541,597.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	10,106,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	187,000.00
210604	Урсгал засвар	-	9,919,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	457,556,178.40	504,432,311.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	457,556,178.40	499,670,246.50

АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ

Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	193,773.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	870,000.00
210807	Газрын төлбөр	-	3,654,292.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,353,543.70	1,671,596,029.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,063,593.00	1,538,500,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,289,950.70	130,095,299.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,811,391.80	1,142,263,817.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	931,389,739.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	846,501,426.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	84,888,313.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	282,811,391.80	210,874,078.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	282,811,391.80	210,874,078.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,505,087,397.30	315,695,507.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	34,055,516.60
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		34,055,516.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,505,087,397.30	281,639,990.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,505,087,397.30	1,505,087,397.30
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,505,087,397.30	1,505,087,397.30
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
19	Тайлант үеийн үр дүн	-	-	281,639,990.60	281,639,990.60
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	1,786,727,387.90	1,786,727,387.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,139,345,200.00	5,399,990,230.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	335,000.00	400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	335,000.00	400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	335,000.00	400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	335,000.00	400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,139,010,200.00	5,399,590,230.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,128,990,200.00	3,898,126,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,128,990,200.00	3,898,126,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,020,000.00	1,501,463,930.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	56,486,175.30
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,444,977,755.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,584,537,700.00	5,392,790,730.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,584,537,700.00	5,392,790,730.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,291,371,308.10	4,243,617,157.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	500,164,242.10	1,690,231,512.90
210101	Үндсэн цалин	278,886,607.10	1,187,892,967.30
210102	Нэмэгдэл	94,455,192.00	260,020,807.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,964,000.00	160,824,973.60
210104	Урамшуулал	82,858,443.00	81,492,765.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,329,267.20	219,478,157.70
210201	Тэтгэврийн даатгал	42,182,291.40	152,137,259.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,061,123.10	16,944,065.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,001,297.30	13,619,731.60
210204	Ажилгүйдлийн даатгал	982,959.50	3,295,242.70
210205	Эрүүл мэндийн даатгал	10,101,595.80	33,481,857.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	144,000,000.00
210304	Байрны түрээс	-	144,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,382,432.70	112,363,339.20
210401	Бичиг хэрэг	17,500,000.00	20,793,340.00
210402	Тээвэр, шатахуун	3,439,253.00	47,193,386.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,529,989.70	35,606,922.20
210404	Ном, хэвлэл	7,965,000.00	1,060,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,948,190.00	6,859,491.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	11,948,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,029,800.00
210604	Урсгал засвар	-	9,919,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,911,486.00	520,000,717.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	633,911,486.00	515,238,652.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	193,773.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	870,000.00
210807	Газрын төлбөр	-	3,654,292.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,583,880.00	1,545,594,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,583,880.00	1,542,594,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,000,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	293,166,391.80	1,149,173,572.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	931,389,739.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	846,501,426.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	84,888,313.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	283,166,391.80	217,783,833.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	282,811,391.80	210,874,078.10
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	355,000.00	6,909,755.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	554,807,500.00	7,199,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	554,807,500.00	7,199,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	554,807,500.00	7,199,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	554,807,500.00	7,199,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	554,807,500.00	7,199,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(554,807,500.00)	(7,199,500.00)
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (XIII)=(III)+(XI)+(XII)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтган хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
X	Мөнгө, түүнтэй адилтган хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,898,126,300.00	3,687,652,221.90	210,474,078.00	94.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,898,126,300.00	3,687,652,221.90	210,474,078.00	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,937,519,300.00	2,756,262,482.40	181,256,817.50	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,786,195,600.00	1,690,231,513.00	95,964,087.00	94.6
210101	Үндсэн цалин	1,236,852,100.00	1,187,892,967.40	48,959,132.60	96.0
210102	Нэмэгдэл	268,933,800.00	260,020,807.00	8,912,993.00	96.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	185,928,000.00	160,824,973.60	25,103,026.40	86.5
210104	Урамшуулал	94,481,700.00	81,492,765.00	12,988,935.00	86.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,215,300.00	219,478,157.70	52,737,142.30	80.6
210201	Тэтгэврийн даатгал	184,855,200.00	152,137,259.90	32,717,940.10	82.3
210202	Тэтгэмжийн даатгал	21,840,000.00	16,944,065.70	4,895,934.30	77.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,472,000.00	13,619,731.70	3,852,268.30	78.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,368,000.00	3,295,242.80	1,072,757.20	75.4
210205	Эрүүл мэндийн даатгал	43,680,100.00	33,481,857.70	10,198,242.20	76.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,000,000.00	144,000,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	144,000,000.00	144,000,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	114,156,700.00	112,363,339.30	1,793,360.70	98.4
210401	Бичиг хэрэг	20,800,000.00	20,793,340.00	6,660.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	47,870,000.00	47,193,386.00	676,614.00	98.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,900,000.00	35,606,922.30	293,077.70	99.2
210404	Ном, хэвлэл	1,876,700.00	1,060,200.00	816,500.00	56.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,000.00	850,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,860,000.00	6,859,491.00	509.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,220,000.00	19,148,400.00	11,071,600.00	63.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,220,000.00	9,229,300.00	10,990,700.00	45.6
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,919,100.00	80,900.00	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	476,441,700.00	470,424,297.50	6,017,402.40	98.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	470,991,700.00	466,532,232.50	4,459,467.40	99.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	193,773.00	6,227.00	96.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	44,000.00	56,000.00	44.0
210807	Газрын төлбөр	5,150,000.00	3,654,292.00	1,495,708.00	71.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,290,000.00	100,616,775.00	13,673,225.00	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,290,000.00	97,616,775.00	13,673,225.00	87.7

Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,607,000.00	931,389,739.50	29,217,260.50	97.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,607,000.00	931,389,739.50	29,217,260.50	97.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	850,000,000.00	846,501,426.00	3,498,574.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,607,000.00	84,888,313.50	25,718,686.50	76.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,898,126,300.00	3,687,652,221.90	210,474,078.00	94.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,898,126,300.00	3,687,252,221.90	210,874,078.00	94.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,898,126,300.00	3,687,252,221.90	210,874,078.00	94.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	400,000.00	(400,000.00)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	400,000.00	(400,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	157	145	12	92.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	78	72	6	92.3
620001	Удирдах ажилтан	16	12	4	75.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59	60	-1	101.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	72	13	92.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	72	59	13	81.9
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3	5	-2	600.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	6	-5	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,501,463,930.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,501,463,930.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,494,554,175.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	49,576,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	48,706,420.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	870,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,444,977,755.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,444,977,755.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,909,755.40
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,909,755.40
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,501,463,930.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,501,463,930.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	56,486,175.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,444,977,755.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёлын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын нөөц үүсгэсэн, төсвийн төлөвлөлт, шууд худалдан авалт зохион байгуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор П.Амарсанаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 3/170 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Соёлын яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Үндэсний соёлын үнэ цэнийг бүс нутагт дээшлүүлэх, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх, улсын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх соёлын засаглалын нэгдмэл, тогтвортой тогтолцоо бүрдүүлэх. Мөн Монгол Улс нь бүс нутгийн хэмжээний соёл хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Кино урлагийг дэмжих сангийн тухай хууль;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” тушаал;
- ЗГ-ын 2021 оны 388 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол;
- ЗГ-ын 2021 оны 291 дүгээр “Ажилд түр томилох тухай” тогтоол;
- Хот, суурин хангамж ариутгах татварын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол 2021 оны 79 дүгээр “Улаанбаатар хотын цэвэр бохир усны үйлчилгээний тариф батлах тухай” тогтоол;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, байгууллагын онцлогт АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ

тохируулан хийхээр Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар бодлогын баримт бичгийн төсөлд дүгнэлт өгч, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь тайлант хугацааны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 7 байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дараах хамрах хүрээгээр дотоод аудитын хяналт шалгалт гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төсвийн санхүүжилт, түүний зарцуулалт тайлагнал;
- Батлагдсан орон тоо, ажиллагсдын цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл шагналт цалин, үр дүнгийн урамшууллын хууль эрх зүйн үндэслэл, тооцоо, бодолт баримт бүрдэл;
- Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтын хууль эрх зүйн үндэслэл, санхүүгийн тайлан үнэн зөв тайлагнасан байдал;
- Байгууллагын үндсэн болон эргэлтийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, хадгалалт, ашиглалт, хамгаалалт;
- Бараа материал, хөрөнгө худалдан авах ажиллагаа, гадны байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, үр дүн, бүртгэл, хөтлөлт.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 3,898,126.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 58,471.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Соёлын яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281,639.9 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	6,909.7	6,909.7
Урьдчилж гарсан тооцоо	82,496.0	43,770.0	(38,726.0)
Бараа материал	114,750.8	168,788.0	54,037.2
Үндсэн хөрөнгө	1,307,840.5	1,567,259.6	259,419.1
Нийт хөрөнгө	1,505,087.4	1,786,727.4	281,640.0
Хуримтлагдсан үр дүн	1,505,087.4	1,786,727.4	281,640.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,505,087.4	1,786,727.4	281,640.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 6,909.7 мянган төгрөг байгаа нь тайлант онд үүссэн нэмэлт төсвийн татаас санхүүжилтийн авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 38,726.0 мянган төгрөгөөр буурч, 43,770.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь “Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг үнэлэх, хэлэлцүүлэх” ажлын төлбөр 11,000.0 мянга, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн соёлын салбарт дэвшүүлсэн зорилт, хэрэгжилтийн явцад бодлогын шинжилгээ хийх” төлбөр 8,910.0 мянга, Соёлын сайдын гадаад айлчлалд зориулсан 5 урлагийн бүтээлийн төлбөр 4,950.0 мянга, “Төрийн албаны ёс зүйн шинэчлэл- Соёлын салбарт” ажлын төлбөр 8,910.0 мянга, Соён гэгээрүүлэх ажлын төлбөрт 10,000.0 мянган төгрөгийг хувь хүн болон хуулийн этгээдтэй гэрээ хийж, тус дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 168,788.0 мянган төгрөг болж, 54,037.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 123,686.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ӨМӨЗО-оос Ковид-19 цар тахалтай холбогдуулан 1,915.0 мянган төгрөгийн бээлий, амны хаалт хандиваар авч 71,563.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,567,259.6 мянган төгрөг болж, 259,419.1 мянган төгрөгөөр өссөн нь:

- Машин тоног төхөөрөмжийн дансанд 7,199.5 мянган төгрөгийн компьютер, тог баригч, хөргөгч худалдаж, Соёлын сайдын хөрөнгө оруулалтын багцаас 46,272.2 мянган төгрөгийн зөөврийн болон суурин компьютер авсан;
- ТӨБЗГ-ийн 2021 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 437 дугаар тогтоолоор Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨҮГ-аас Соёлын яамны түрээсийн байр ашиглалттай холбоотой 127,416.7 мянган төгрөгийн хурлын өрөөний тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шилжүүлэн өгсөн;
- Төрийн байгууллагын газар эзэмших 000014966 дугаартай гэрчилгээний “Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын цогцолбор” барих зориулалтаар 242,681.2 мянган төгрөгийн эзэмших зориулалттай 10,991 м² газрыг биет бус хөрөнгө дансанд бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Зөвшөөрөл олгох тухай” А-1/1609 дугаар албан бичгээр тавилга, эд хогшил данснаас 11,700.2 мянган төгрөгийн 40 ширхэг сандлыг Чингис хаан музейд, ТӨБЗГ-ын 2021 оны “Зөвшөөрөл олгох тухай” А-1/1788 дугаар албан бичгээр тоног төхөөрөмж данснаас 27,428.5 мянган төгрөгийн хурлын өрөөний тоног төхөөрөмжийг Монголын Үндэсний музейд тус тус балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 126 дугаар тогтоолоор 14,584.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг данснаас хасаж, Хэнтий аймгийн Бэрх сумын соёлын ордонд шилжүүлсэн байна.

Хуримтлагдсан үр дүн 1,786,727.4 мянган төгрөг болж 281,640.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,910,607.3 мянган төгрөгөөр буюу 100.1 хувиар өссөн нь ЗГ-ын 2020 оны “Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон хязгаарыг батлах тухай” 10 дугаар тогтоолоор 2020 оны 7 сарын 16-наас эхэлж Соёлын яам нь шинээр зохион байгуулагдаж, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,769,136.1 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 1,501,463.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсөвт байгууллагын өөрийн орлого 359,992.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансаар Юнескогийн 450035906 гэрээний дагуу 56,486.1 мянга, Засгийн газрын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” 128 дугаар тогтоолоор филармонийн хөгжмийн зэмсэг авах санхүүжилтэд 923,962.3 мянга, Дээд шатны төсөв захирагчаас 306,515.4 мянга, Монгол улсын үндэсний урлагийн их театрын барилгын зураг төсвийн санхүүжилтэд 214,500.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,769,136.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Соёлын яамны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,877,252.3 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 2,877,252.3 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, БШУЯ-аас Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

ЗГ-ын 2020 оны “Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон хязгаарыг батлах тухай” 10 дугаар тогтоолоор Соёлын яам 2020 оны 7 сарын 16-наас үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул Төсвийн захирагчийн хүргүүлсэн саналыг 1,020,874.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,898,126.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,898,126.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,898,126.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 400.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,687,652.2 мянган төгрөгийг зарцуулж 210,874.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,687,652.2 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал зардлыг 95,946.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 52,737.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1,793.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,071.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 6,017.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 13,673.2 мянган төгрөг, бусад

урсгал шилжүүлэг 29,217.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 145,679.7 мянган төгрөгөөр, соёл урлаг хөтөлбөрийн гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ арга хэмжээ 34,690.0 мянган төгрөгөөр, соёл урлаг хөтөлбөрийн байр ашиглалтын үйлчилгээ арга хэмжээ 887.8 мянган төгрөгөөр, соёл урлаг хөтөлбөрийн ахмад дайчин, алдар цолтой ахмад арга хэмжээ 3,498.5 мянган төгрөгөөр, соёл урлаг арга хэмжээ хөтөлбөрийн ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээ 24,718.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71701	Соёл урлаг	3,898,126.3	3,687,652.2	210,474.1	94.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,619,886.0	2,474,206.3	145,679.7	94.4
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	85,125.0	50,435.6	34,690.0	59.2
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	232,508.3	231,620.5	887.8	99.6
1.4	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад	850,000.0	846,501.5	3,498.5	99.6
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	110,607.0	84,888.3	25,718.7	76.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Юнескогийн төсөл хөтөлбөрөөс 56,486.2 мянга, Засгийн газрын нөөц сангаас 1,138,462.3 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 306,515.5 мянга, нийт 1,501,464.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс филармонийн хөгжмийн зэмсэг худалдан авахад 1,230,477.9 мянга, Монгол улсын үндэсний урлагийн их театрын барилгын зураг, төсвийн үлдэгдэл төлбөрт 214,500.0 мянга, Zoom программын лиценз авахад 870.0 мянга, гэрээгээр гүйцэтгүүлсэн Юнескогийн “Соёлын биет бус өвийг хамгаалах” төслийн орчуулгын төлбөрт 48,706.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6,909.7 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цаашид зардлын эдийн засгийн ангиллын хүрээнд батлагдсан төсөвтөө захирагдан үйл ажиллагаа явуулах, ЗГ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолын биелэлтийг хангуулж, 2022 онд төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах асуудлыг онцолж байна.

“Төрийн албаны ёс зүйн шинэчлэл Соёлын салбарт”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн соёлын салбарт дэвшүүлсэн зорилт, хэрэгжилтийн явцад бодлогын шинжилгээ хийх” зэрэг адил төстэй ажлуудыг бусдаар гүйцэтгүүлэн урьдчилгаа

олгохдоо ач холбогдол, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж салбарын дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж зохион байгуулах нь ач холбогдолтой байна.

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд эцэслэн боловсруулж дуусаагүй тул нийтээр дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн онцлог, шинээр батлагдсан, өөрчлөн найруулсан хууль, тогтоомж, тушаалын өөрчлөлтүүдийг тусгасан эсэхийг аудитаар тодорхойлох боломжгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд Соёлын яамны 2021 оны 3/1957 дугаар албан бичгээр Монгол Улсын Үндэсний урлагийн их театрын барилгын төсөвт өртгийг 152,520,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад саналыг хүргүүлсэн. Дээрх барилгын зураг, төсвийн экспертизийн магадлалын дүгнэлтэд төсөвт өртөг 177,209,032.9 мянган төгрөгөөр баталгаажсан боловч хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 24,689,032.9 мянган төгрөгийн зөрүүтэй дүнгээр суурь, судалгаагүй ажлыг тусгуулахаар санал хүргүүлсэн байна.

Түүнчлэн барилгын зураг, төсвийг яамны санхүүгийн тайланд хуримтлуулан бүртгээгүй нь төрийн, нийтийн өмчид бүртгэлээр тавих хяналт алдагдах эрсдэл үүсгэж байгааг төсөв захирагчийн анхааралд хүргэх аудитын гол асуудал болгон дурдаж байна.

Мөн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, хөрөнгө худалдан авсан, засварын ажил санхүүжүүлсэн болон зураг төсөвтэй холбоотой дээрх асуудал нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц эрсдэл үүсгэж байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд 149 мэдээлэл байршуулахаас, 144 мэдээллийг хугацаандаа оруулж, 5 мэдээлэл хугацаа хоцроосон байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 27,606.1 мянган төгрөгийн үнэ бүхий оффис 365 хэрэглээний программыг тендерийн цахим хуудсанд зарлан мэдээлэхгүй шууд худалдан авалт хийсэн нь Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ" хавсралтын 4 "Цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийн доод хязгаараас давсан бараа, ажил, үйлчилгээг тендерийн цахим хуудсанд худалдан авалтын урилгыг нийтэд зарлаж, нийлүүлэгчийг шалгаруулан гэрээ байгуулж ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа, шилэн дансны хуульд заасан мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, заавар журамтай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 831,300.0 мянган төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй 50 хувь, аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	831,300.0	1	415,700.0	1	415,700.0	50.0
Зөвлөмж	1	-	1	-	1	-	100.0
Нийт дүн	2	831,300.0	2	415,700.0	2	415,700.0	75.0

Цалин, урамшуулал олгохдоо өөртөө болон дээд албан тушаалтанд илүү цагийн хөлс олгосон зөрчилд өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн, зориулалт бусаар зарцуулсан 39,316.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх онд өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжээгүй байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Соёлын яамны 2022 оны төсөвт мэдээлэл, сурталчилгааны зардал 967,573.7 мянган төгрөгөөр батлагдсан байна. Дээрх төсвийг хэрэгжүүлэхдээ яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан зарцуулах. Тус зардлын ангиллаас хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хаалтын гэрээ хийх эрсдэлтэй тул горим сорил хэрэгжүүлэн, үр дүнг нэгтгэн дүгнэхийг дараагийн аудитаар анхаарах асуудал болгон тодорхойлж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79,093.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 20,777.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 58,316.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 58,316.1 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 58,471.9 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын данснаас бөөн дүнгээр 20,377.5 мянган төгрөгийн зарлага хийснийг буцаан данс бүртгэлд тусгасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд туслах үйл ажиллагааны орлого 400.0 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн;

4.2 Албан шаардлага

1. Тайлант оны үр дүнгийн хурлын видео контент хийлгэхэд 19,000.0 мянга мянган төгрөг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.7 "Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх", мөн тогтоолын 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", мөн хуулийн 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

2. Тайлант онд Соёлын яамны барилгын шат болон коридорт хивс дэвсэх ажлын 11,573.2 мянга, Зоорины давхрын өрөөг дахин засварлах ажлын 18,809.6 мянга, архив болон цайны өрөө засварлах ажлын 8,933.3 мянга, нийт 39,316.1 мянган төгрөгийн урсгал засварын шинжтэй ажлыг зардлын ангилал зөрчин бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас санхүүжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Ардын авьяастан, Соёлын яамны жуух бичиг, Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон дагалдах үнэмлэх, хавтас, жуух бичиг нийт 7,050.0 ширхэг 20,377.5 мянган төгрөгийн шагналын нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын их хэмжээний нөөц үүсгэхгүй байх, төсвийг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны зардлыг тохирох эдийн засгийн ангилалд төлөвлөж, тайлагнаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж ангиллаас 38,125.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-д "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зардлыг тохирох эдийн засгийн ангилалд төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
					/мянган төгрөгөөр/									
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Тайлант онд Соёлын яамны шат болон коридорт хивс дэвсэх ажлын 11,573.2 мянга, өмнөх онд засвар хийсэн Зоорийн давхрын өрөөг дахин засварлах ажлын 18,809.6 мянга, архив болон цайны өрөө засварлах ажлын 8,933.3 мянга, нийт 39,316.1 мянган төгрөгийн урсгал засварын шинжтэй ажлыг зардлын ангилал зөрчин бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас санхүүжүүлсэн байна.	Албан шаардлага	1	39,316.1					1	39,316.1		
2	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Тайлант оны үр дүнгийн хурлын видео контент хийлгэхэд 19,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.	Албан шаардлага	1	19,000.0					1	19,000.0		
3	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Ардын авьяастан, Соёлын яамны жуух бичиг, Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон дагалдах үнэмлэх, хавтас, жуух бичиг нийт 7,050.0 ширхэг мянган 20,377.5 төгрөгийн шагналын нөөц үүсгэсэн байна.	Зөвлөмж	1								1	-
4	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Ардын авьяастан, Соёлын яамны жуух бичиг, Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон дагалдах үнэмлэх, хавтас, жуух бичиг нийт 7,050.0 ширхэг мянган 20,377.5 төгрөгийн шагналын бөөн дүнгээр зарлага хийсэн.	Залруулах	1	20,377.5	1	20,377.5						
5	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд туслах үйл ажиллагааны зардал 400.0 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн	Залруулах	1	400.0	1	400.0						

**Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

6	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Монгол улсын 2022 оны төсвийн төсөлд Соёлын яамнаас 2021 оны 3/1957 тоот албан бичгээр Монгол улсын Үндэсний урлагийн их театрын барилгын төсөвт өртгийг 152,520,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад саналыг хүргүүлсэн. Харин дээрх барилгын зураг, төсвийн экспертизийн магадлалын дүгнэлтэд төсөвт өртөг 177,209,032.9 мянган төгрөгөөр баталгаажсан боловч сайдын багцын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 24,689,032.9 мянган төгрөгийн зөрүүтэй дүнгээр суурь, судалгаагүй ажлыг тусгуулахаар санал хүргүүлсэн байна.	Албан шаардлага	1	-					1	-		
7	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Батлагдсан төсөвт байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны зардлыг тохирох эдийн засгийн ангилалд төлөвлөж, тайлагнаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж ангиллаас 38,125.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.	Зөвлөмж	1	-							1	-
ДҮН					7	79,093.6	2	20,777.5	-	-	3	58,316.1	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 149 мэдээлэл байршуулахаас, 144 мэдээллийг хугацаандаа оруулж, 5 мэдээлэл хугацаа хоцроосон байршуулсан байна.	Албан шаардлага	1	-					1	-		
2	Соёлын яам	АХГ-2022/148/НА-СТА-ТШЗ	Оффис 365 программыг 27,606.1 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн.	Зөвлөмж	1	27,606.1							1	27,606.1
ДҮН					2	27,606.1	-	-	-	-	1	-	1	27,606.1
НИЙТ ДҮН					9	106,699.7	2	20,777.5	-	-	4	58,316.1	3	27,606.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 37/А0170064
АХГ-00 02/148/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны үр дүнгийн хурлын видео контент хийлгэхэд 19,000,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.7 "хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Ахлах нягтлан бодогч Н.Даваацэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
П.АМАРСАНАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 36/20170364

Улаанбаатар хот

АХГ-2022/148/НА-СГА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Соёлын яамны байрны шат болон коридорын тохижилтын ажлын 11,573,200.00 төгрөг, зоорийн давхрын өрөөг засварлах ажлын 18,809,600.00 төгрөг, архив болон цайны өрөө засварлах ажлын 8,933,300.00 төгрөг, нийт 39,316,100.00 төгрөгийн урсгал засварын ажлыг, батлагдсан төсвийн ангилал зөрчиж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зардлын ангиллын дагуу зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Ахлах нягтлан бодогч Н.Даваацэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

П.АМАРСАНАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бичиг тойруу-1, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-2642.00

145.10.10.2016/АХГ_Хянгын/20220225_Аудит 7 Газар-112.Docx

0010800347



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 95/АО170064
АХГ-0020/НЗ/МА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Соёлын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, төвлөрүүлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хэмжээнд орсон өөрчлөлт, төсөв, хөрөнгө мөнгө, зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Ахлах нягтлан бодогч Н.Даваацэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
П.АМАРСАНАА